

ГАЗАРЗҮЙ


2011

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ


- Нарны аймгийн дараах гаригуудын аль нь дэлхийтэй төстэй вэ?
 А. Ангараг В. Бархасбадь С. Дэлхий ван D. Санчир E. Тэнгэрийн ван
- 3 сарын 21 нд нар хаана эгц тусдаг вэ?
 А. ХӨ 23,5° В. Экватор С. ӨӨ 23,5° D. ХӨ 66,5° E. ӨӨ 66,5°
- Далай, тэнгисийн усны түвшин хоёр удаа дээшилж доошлон татралт түрэлт үүсдэг. Үүний гол шалтгаан юу вэ?
 А. Сарны татах хүч В. Кориолисийн хүч
 С. Дэлхийн нарыг тойрох хөдөлгөөн D. Дэлхийн тэнхлэгээ тойрох хөдөлгөөн
 E. Төвөөс зугатаах хүч
- Дараах чулуулгуудаас аль нь магмын чулуулаг вэ?
 А. Боржин, хүрмэн чулуу В. Шаварлаг занар, чулуун нүүрс
 С. Гантиг, гялтгануур D. Хөөсөн чулуу, шохойн чулуу
 E. Талст занар, хээрийн жонш
- Чулуун мандалд явагддаг дараах үзэгдлүүдээс аль нь гадаад хүчний гаралтай үйл явцад хамаарах вэ?
 А. Тектоникийн хавтангууд бие биенийхээ хажуугаар шилжих
 В. Рифтийн хөндий үүсэх
 С. Галт уул дэлбэрэх
 D. Уулын чулуулаг өгөршилд орох
 E. Магма газрын царцдаст давхрага руу түрэн орж царцах
- Тунадасны нэг өвөрмөц төрөл болох мөндөр ямар үүлнээс ордог вэ?
 А. Доод мандлын давхраат бөөн В. Доод мандлын давхраат
 С. Босоо хөгжлийн борооны бөөн D. Босоо хөгжлийн бөөн
 E. Дунд мандлын өндрийн бөөн
- Дараах зурагт 4 тоогоор далайн ямар урсгалыг тэмдэглэсэн байна вэ?

- Бенгелийн хүйтэн урсгал
- Мозамбикийн дулаан урсгал
- Сомалийн хүйтэн урсгал
- Анголын дулаан урсгал
- Гвинеин дулаан урсгал




- Дараах нууруудаас хамгийн нам газар орших нуур аль нь вэ?
 А. Сөнөсөн тэнгис В. Виктори С. Байгаль D. Ньяса E. Титикака
- Металл биш элементүүдийн хүчилтөрөгчтэй нэгдсэн нэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?
 А. Галиодууд В. Сульфатууд С. Исэл, услаг ислүүд
 D. Сульфидууд E. Дан эрдэс
- Португалийн колони байсан Африк тивийн улс аль нь вэ?
 А. Бразил В. Ангол С. Макао D. Шинэ-Зеланд E. Болив
- 1:6 000 000 масштабтай зурагт А гол 4 см урт зурагдсан бол голын урт хэд вэ?
 А. 240 км В. 24 км С. 2400 км D. 150 км E. 64 км
- Скандиновын хойгийн Балтийн тэнгисийн эрэгт орших хаант засаглалтай улс аль нь вэ?
 А. Финланд В. Дани С. Норвеги D. Эстон E. Швед
- Газарзүйн байрлалын давуу талаа ашиглан хөгжингүй улс болсон Азийн улсын нэр юу вэ?
 А. Панам В. Египет С. Сингапур
 D. Финланд E. Австрали

14. Обь, Енисей, Лена, Амур мөрний савд орших бүс нутаг аль нь вэ?
 А. Баруун Ази В. Умард Ази С. Өмнөд Ази
 D. Төв Ази E. Зүүн Ази
15. Дэлхийд хамгийн олон хүн ярилцдаг хэлний бүлэг аль нь вэ?
 А. Герман В. Урал С. Хятад-Төвд D. Славян E. Алтай
16. Дэлхийн хамгийн их усны эрчим хүч агуулсан гол мөрний ай сав аль нь вэ?
 А. Амазонк В. Конго С. Хөх D. Енисей E. Меконг
17. Кофены тариалалт, экспортоор тэргүүлэх бүс нутаг, улс аль нь вэ?
 А. Дорнод Африк, Эфиоп, Танзани В. Өмнөд Америк, Бразил, Колумб
 С. Зүүн Өмнөд Ази, Тайланд, Малайз D. Баруун Африк, Нигери, Гана
 E. Өмнөд Африк, Ангол, Ботстван
18. Дараах голуудаас аль нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг вэ?
 А. Эг, Идэр В. Онон, Хэрлэн С. Завхан, Ховд
 D. Эг, Таац E. Улз, Байдраг
19. Дараах нууруудаас аль нь цөмрөлөөс үүссэн хотгорт тогтсон нуур вэ?
 А. Шаварт, Чух В. Увс, Хяргас С. Хөвсгөл, Хөх нуур
 D. Тэрхийн цагаан, Шарга E. Толбо, Хяргас
20. Тропосферийн агаар хаанаас дулаанаа авах вэ?
 А. Нарнаас ирсэн шулуун цацрагаас В. Дэлхийн гадаргаас
 С. Агаар мандлаас сарнисан цацрагаас D. Озонд шингэсэн хэт ягаан туяанаас
 E. Нарны ойсон цацрагаас
21. Хүйтэн улиралд гаднаас гэрт оруулж ирсэн сүх цантдаг, дулаан улиралд мөн гаднаас гэрт оруулж ирсэн дүүрэн устай бидон хөлөрдгийн учир юу вэ?
 А. Гадаа ба гэрийн агаарын температур ижил байгаа учраас
 В. Гадаа илүү дулаан байсан учраас
 С. Хүйтэн биеийн гадаргууг шүргэсэн дулаан агаар хөрч өтгөрснөөс
 D. Дулаан агаарын ууршилт явагдсанаас
 E. Хүйтэн биет хөрсөнөөс болж дулаанаа гадагш алдсан
22. Ачаа тээвэр гэдэг нь ямар ойлголт вэ?
 А. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ
 В. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замаар нь үржүүлсэн үзүүлэлт
 С. Агаарын замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ
 D. Хуурай замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ
 E. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ
23. Салхи үүсэх шалтгаан аль нь вэ?
 А. Кориолисийн хүч В. Агаарын даралтын зөрүү
 С. Агаарын чийглэгийн ялгаа D. Дэлхийн эргэлт
 E. Нар сарны татах хүч
24. Зүүн өмнөд Азийн орнуудын эвсэл АСЕАН-ийн гишүүн орныг сонгоно уу.
 А. Солонгос В. Япон С. Лаос D. Хятад E. Энэтхэг
25. Үндэстэн гэдэг ойлголт аль нь вэ?
 А. Хүмүүс мах цусны төрөл, садангаар хамтран амьдрах байдал
 В. Овгууд хоорондоо нэгдсэн угсаатны нэгдэл
 С. Овог, аймаг, үндэстэн зэргийг хамтад нь
 D. Нийтлэг нэг хэл соёл, зан заншилтай бол
 E. Ястнуудын нэгдсэн хэлбэр
26. Тэжээлийн таримлын газар тариаланд үзүүлэх гол ач холбогдол нь юу вэ?
 А. Мал аж ахуйг тэжээлээр хангах
 В. Үйлдвэрт ашиглагдах
 С. Хүнсний үйлдвэрийн хэрэгцээнд ашиглагддаг
 D. Тариалангийн газрын хөрсний үржил шимийг бууруулдаггүй
 E. Тариалангийн үйлдвэрийн шинэ салбар болж байна
27. Аливаа цэгийн газарзүйн солбицлыг орших уртраг ба өргөргөөр нь тодорхойлдог. Дараах солбицолд орших цэгүүдээс өргөргийн дагуу хамгийн хол ба ойр орших цэгүүдийг олно уу.
 А. KP; WG В. WG; QR С. QR; SB
 D. KP; SB E. KW; PG



28. Дараах ан амьтдаас ховор ангилалд ордоггүй амьтдыг олно уу.
 А. Тахь, мазаалай, ирвэс
 В. Хавтгай, хар мөрний хандгай, цөөвөр чоно
 С. Минж, халиу, гангар хун
 D. Монгол бөхөн, соргог бөхөн, халим загас
 E. Цагаан зэр, чоно, тарвага
29. Далайн урсгалыг зурагзүйн ямар аргаар дүрсэлбэл тохиромжтой вэ?
 А. Хөдөлгөөнт шугамын
 В. Картограммын
 С. Картодиаграммын
 D. Аралын
 E. Тэмдгийн
30. Аж үйлдвэрийн зангилаа гэж юуг хэлэх вэ?
 А. Хот сууринд хооронд хэлхээ багатай ганц хоёр үйлдвэрийн газар байгааг
 В. Хоорондоо хэлхээ багатай хэд хэдэн үйлдвэрийн газар төвлөрсөн суурин газрыг
 С. Хот, суурин газарт хоорондоо холбоотой үйлдвэрийг бөөгнөрүүлэн байршуулсныг
 D. Тээврийн зангилаан дээр үйлдвэрүүдийг байршуулсныг
 E. Олон үйлдвэр бүхий тээврийн зангилаа
31. Нохойн хошуу, гүйлс, шинэс зэрэг ургамлууд нь байгалийн ямар бүс, бүслүүрт түгээмэл тархан ургадаг вэ?
 А. Говийн ба цөлийн бүс
 В. Хээрийн бүс
 С. Ойт-хээрийн бүс
 D. Тайгын бүслүүр
 E. Тагийн бүслүүр
32. Дэлхийн байгаль хамгаалах сангаас тусгай хамгаалалтанд авсан 200 эко бүсэд Монголын ямар 2 газар орсон бэ?
 А. Найман нуур, Эрээн цав
 В. Өгий нуур, Тэрхийн цагаан нуур
 С. Увс нуурын ай сав, Монгол дагуур
 D. Таван богд, Хөвсгөл нуур
 E. Их нууруудын хотгор, Хөвсгөл нуурын ай сав
33. Дараах хаяалбараас N цэгийн өндрийг тодорхойлно уу.


- А. 300 м
 В. 150 м
 С. 550 м
 D. 350 м
 E. 150 м



34. Дараах уулуудыг баруунаас зүүн тийш орших дарааллаар нь зөв бичсэн хариултыг сонго.
 1. Батхаан
 2. Цамбагарав
 3. Отгонтэнгэр
 4. Асралт хайрхан
 5. Таван богд
 А. 1, 3, 5, 4, 2
 В. 3, 1, 4, 5, 2
 С. 4, 1, 5, 2, 3
 D. 1, 3, 2, 4, 5
 E. 5, 2, 3, 1, 4
35. Монгол оронд байгалийн үндсэн гол ямар бүсүүд байдаг вэ?
 А. Ойт хээр, ойн бүс, цөлийн бүс, саванны бүс
 В. Тайгын бүс, мөнх цэвдэгийн бүс, халуун орны цөлийн бүс
 С. Тагийн бүс, арктикийн бүс, говийн бүс
 D. Говь-цөлийн, хээр, ойт хээр
 E. Аль нь ч биш
36. Азот агаар мандалд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
 А. Организмуудын амьсгалах болон аливаа исэлдэх явцад оролцоно.
 В. Ургамалд органик бодис бүрэлдэхэд оролцоно.
 С. Хүчилтөрөгчийг шингэлнэ.
 D. Фотосинтезийн үйл явцад оролцоно.
 E. Нарнаас ирэх хэт ягаан туяаг шингээнэ.
37. Гадаргын нэгж талбайд ирэх нарны цацрагийн хэмжээ юунаас хамаарах вэ?
 А. Гадаргын физик шинжээс
 В. Хөрс ургамлын байдлаас
 С. Далай эх газрын байрлалаас
 D. Нарны цацрагийн гадаргад тусах өнцгөөс
 E. Гадаргын химийн шинж чанараас


38. Доорх зурагт 1, 2, 3 гэсэн тоогоор тэмдэглэсэн хуудасны нэрлэлийг зөв дугуйлна уу.

- A. 1 L - 49 2 M - 48 3 M - 47
- B. 1 L - 49 2 M - 50 3 M - 47
- C. 1 L - 47 2 M - 48 3 L - 46
- D. 1 L - 50 2 M - 45 3 K - 48
- E. 1 L - 47 2 M - 48 3 K - 48



39. Монгол улсын газрын зурагт 11 тоогоор тэмдэглэсэн хилийн боомтын нэр юу вэ?

- A. Гашуун сухайт
- B. Бичигт
- C. Арцсуурь
- D. Хавирга
- E. Шивээхүрэн



40. Циклон бүрэлдсэн үед цаг агаар ямар болох вэ?

- A. Төвдөө их даралттай, агаар өгсөх хөдөлгөөнд орно, тэнгэр цэлмэг, хур тунадастай, агаар тогтворгүй, салхи тогтуун
- B. Төвдөө бага даралттай, агаар өгсөх хөдөлгөөнд орно, тэнгэр бүрхэг, хур тунадастай, агаар тогтворгүй, салхитай
- C. Төвдөө бага даралттай, агаар уруудах хөдөлгөөнд орно, тэнгэр бүрхэг, хур тунадасгүй, агаар тогтвортой, салхи тогтуун
- D. Төвдөө их даралттай, агаар уруудах хөдөлгөөнд орно, тэнгэр цэлмэг, хур тунадасгүй, агаар тогтвортой, салхи тогтуун
- E. Төвдөө их даралттай, агаар уруудах хөдөлгөөнд орно, тэнгэр цэлмэг, хур тунадастай, агаар тогтвортой, салхитай


41. Эрдэнэт хот ХӨ 49° 01', ЗУ 104° 01'-д оршдог. Тэгвэл матрын зам дээр нар эгц байх үед Эрдэнэт хотод үдийн нарны өндөр хэд байхыг бодож олно уу.

- A. 65° 36' B. 42° 51' C. 17° 32' D. 16° 15' E. 35° 49'

42. Ямар үед ууршилт их явагдах боломжтой вэ?

- A. Харьцангуй чийг бага үед
- B. Үнэмлэхүй чийг бага үед
- C. Агаарын температур шүүдэр цэгтээ хүрсэн үед
- D. Салхи ихтэй үед
- E. Агаар их халуун үед

43. Дараах бүдүүвчийн хоосон нүдэнд тохирох хариултыг сонгоно уу.



- A. Насанд хүрээгүй хөдөлмөр эрхлэгчид
- B. Нас хэтэрсэн ба насанд хүрээгүй хөдөлмөр эрхлэгчид
- C. Гэрийн ажилтай хүн ам
- D. Хөдөлмөрийн чадваргүй хүн ам
- E. Нас хэтэрсэн хөдөлмөр эрхэлдэг хүн ам

44. “Хүний хөгжлийн индекс” (ХХИ) нь улс орны хөгжлийн түвшинг илэрхийлдэг үзүүлэлт юм. Дараах улсуудаас ХХИ-ээр дэлхийд эхний 10-д багтах 3 орон аль нь вэ?

- A. Швейцар, Норвеги, Австрали
- B. Бразил, Мексик, Саудын Араб
- C. Энэтхэг, Малайз, Казахстан
- D. Алжир, Хятад, Индонез
- E. Тайланд, Аргентин, Венесуэл


45. Тэгш хэвтээ байрлалтай чулуулгийн үе давхаргууд тектоник хөдөлгөөнөөр цуурч зөрөн томоохон хөндий хотгорыг үүсгэдэг. Энэ мэдээллээс үндэслэж рифтийн хөндийд үүссэн Африк тивийн нэгэн нуурыг нэрлэнэ үү.

- A. Ладог B. Балхаш C. Ньяса D. Баавгай нуур E. Гурон

46. Эх газрын тан буюу шельф гэж юуг хэлдэг вэ?
 А. Далай эх газрын зааг шугам
 С. Далайн 1500 м хүртэлх гүн хэсэг
 Е. Далай руу түрж орсон эх газрын 200 м хүртэлх гүн хэсэг

- В. Далайн 1000 м хүртэлх гүн хэсэг
 D. Нуурын эргийн хэсэг

47. Төвийн бүсийн нүүрсний уурхайнуудыг харуулсан дараах зураг дээр 8 тоогоор тэмдэглэгдсэн нүүрсний уурхайн нэр юу вэ?
 А. Шарын гол
 В. Багануур
 С. Тавантолгой
 D. Нарийн сухайт
 Е. Тэвшийн говь




48. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр ойрын өдрүүдэд агаарын даралт буурна гэлээ. Тэнгэр ямар болох вэ?
 А. Тэнгэр муухайрна, тогтворгүй болно, дулаарна
 В. Тэнгэр цэлмэж, тогтуун болно
 С. Салхигүй болно
 D. Цаг агаар тогтвортой болно
 Е. Хур тунадасгүй болно

49. Үйлдвэрлэлийн хоршилт гэж юуг хэлэх вэ?
 А. Том үйлдвэрийн газар үйлдвэрлэл төвлөрөхийг
 В. Үйлдвэрийн газрууд нэг төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах
 С. Төрөлжсөн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг толгойлох үйлдвэрт нийлүүлж бэлэн бүтээгдэхүүн хийх
 D. Нэг төрлийн түүхий эдээр олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг нэгтгэх
 Е. Зөв хариулт байхгүй

50. Орчин үед эрчим хүчний найдвартай, хямд эх үүсвэрийг хайх болсны нэг нь гол мөрөн, нуурын усны уналтын хурдыг ашиглах явдал юм. Үүний тулд гол мөрдийн ямар үзүүлэлтийг голлон анхаарах ёстой вэ ?
 А. Гол мөрдийн эргийн хэлбэр, зах зээлд ойр, зан заншилд нөлөөлөх эсэх
 В. Байгалийн нөлөөлөл, гол мөрдийн эрдэжилт, уламжлалт ёс, хэв маяг
 С. Гол мөрдийн загасны нөөц, урсгалын голдирол, нутгийн иргэд
 D. Байгаль орчны нөлөөлөл, голын урсац, зарцуулалт, орон нутаг
 Е. Гол мөрдийн эрдэжилт, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл


51. Атлантын далайн гадаргын усны дундаж давсжилт нь бусад далайтай харьцуулахад илүү их байдаг. Гэвч Африкийн эрэг дээр орших Б цэг дээр А цэгийг бодвол давсжилт бага байдгийн гол 2 шалтгаан юу вэ? (3 оноо)
 А. Тунадас бага, ууршилт их
 В. Далайн хүйтэн урсгал ба газарзүйн байрлал
 С. Голын усаар цэнгэгждэг, агаарын тунадас их
 D. Агаарын даралт их ба цөлийн нөлөө
 Е. Гадарга ба ургамлын бүрхэвч



52. Цэгийн оронд тохирох үгийг зөв нөхөж бичих хариултыг сонгоно уу.
 Манай орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоход:
 1. 2. 3. агаарын массууд нөлөөлдөг.
 А. Хүйтэн, дулаан, сэрүүн
 В. Дулаан фронт, уруудах, өгсөх
 С. Арктикийн, сэрүүн бүсийн, дулаан орны
 D. Хүйтэн фронт, дулаан фронт, сэрүүн агаар
 Е. Чийглэг, өмнийн дулаан, сибирийн
53. Газрын тос экспортлогч орнуудын холбоо буюу ОПЕК-ийн гишүүн орон аль нь вэ?
 А. ОХУ, Грек, ОХУ
 В. Австрали, АНУ, Англи
 С. Бразил, Энэтхэг, БНХАУ
 D. Аргентин, БНХАУ, АНУ
 Е. Катар, Ирак, Иран

54. Дараах зургийг ажиглаад, харлуулсан хуудасны нэрлэл аль нь болохыг тодорхойлно уу.

- A. К - 49 - 87
- B. М - 49 - 87
- C. К - 48 - 87
- D. L - 49 - 87
- E. L - 48 - 87



55. Хүснэгтэд өгөгдсөн мэдээллүүдийг зөв харгалзуулна уу.

Газарзүйн байрлал	Дугаар	Улс орнууд	Тэмдэглэгээ
Эх газрын	1	Иран, Ирак	а
Тэнгис орчмын	2	Энэтхэг, Солонгос	б
Арлын	3	Афганистан, Узбекистан	в
Хойгийн	4	Шри-Ланк, Индонез	г


- A. 1в, 2а, 3б, 4в
- B. 1а, 2в, 3г, 4б
- C. 1в, 2а, 3г, 4б
- D. 1аб, 2г, 3б, 4г
- E. 1а, 2в, 3г, 4б

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Хэрэв бодлогын хариу 98 гарсан гэж үзвэл а-9, в-8 гэж бөглөнө, 1967 гэж гарсан бол а-1, в-9, с-6, d-7 гэж бөглөнө.
- Цагийн бодлогын хариуг доорх хэлбэрээр бөглөнө. Жишээлбэл: өглөөний 6 цаг бол 06 буюу а-0, б-6, оройн 6 цаг бол 18 буюу а-1, б-8 гэж бөглөнө.

- 2.1. Туул голын урт 800 км. Эх нь д.т.д 2500 м, цутгал газрынх нь өндөр д.т.д 850 м бол уг голын унал хэд вэ?
- 2.2. Тухайн үеийн агаарын температур нь -10°C . Чийгийн багтаамж 2.5 г/м^3 , харьцангуй чийг 80% байсан бол үнэмлэхүй чийгийг ол.
- 2.3. Далайн мандалд орших усан онгоцноос далайн ёроол руу дууны долгион илгээхэд илгээсэн долгион 6 секундын дараа эргэж ирсэн бол далайн мандлаас ёроол хүртэлх зайг ол. (Усанд дууны долгион тархах хурд 1500 м/с)
- 2.4. Анхны голдоч дээр 10:00 цаг болж байхад аль уртраг дээр 18 : 00 цаг болж байх вэ?



ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нарны аймгийн дараах гаригуудаас нарнаас 5 дахь байрлалд орших гариг аль нь вэ?
А. Ангараг В. Дэлхий С. Санчир
D. Бархасбадь E. Буд
2. Геологийн цаг тооллын нэгж нь галав юм. Дараах галавуудаас аль нь эртнийх вэ?
А. Цэрд В. Юра С. Кембр
D. Ордовик E. Триас
3. Газрын зурагт агуулагдсан бүх төрлийн мэдээллийг уншиж, ойлгож, хэрэглэхийн тулд газрын зургийн ямар элементийг зайлшгүй мэддэг байх ёстой вэ?
А. Масштаб В. Ерөнхийлөл С. Таних тэмдэг
D. Нэрлэл E. Тусгаг
4. Дэлхийн гурван гол шашны нэг нь Христос юм. Энэ шашин дэлхийн аль бүсэд өргөн дэлгэрсэн бэ?
А. Зүүн Ази В. Хойд Америк ба Европ С. Ойрх Дорнод
D. Зүүн өмнөд Ази E. Энэтхэг, Бангладеш
5. Дараах эх газруудаас аль нь Гондваний эх газарт багтаж байсан бэ?
А. Хойд америк В. Еврази С. Арктик
D. Гренланд E. Өмнөд Америк
6. Дараах үйл явцуудын аль нь хүйтний өгөршилд хамрагдах вэ?
А. Уулын чулуулгийн эрдсийн найрлага өөрчлөгдөн үйрч бутрах
B. Чулуулгийн ан цав дахь ус хөлдөж тэлснээс чулуулаг үйрч бутрах
C. Боржин өгөршиж шаазангийн шавар болох
D. Магмын чулуулаг боксит болж хувирах
E. Ургамлын үндэсний хөгжлөөс болж чулуулаг бутрах
7. Дараах тодорхойлолтуудаас харьцангуй чийгийн тодорхойлолтыг зөв сонго.
А. Тодорхой температуртай агаарын шингэж болох усны уурын дээд хэмжээ
B. Тухайн агаарт байгаа чийгийн бодит хэмжээ
C. Агаарын үнэмлэхүй чийг ба чийгийн багтаамж хоёрын ялгавар
D. Тодорхой температуртай агаарын үнэмлэхүй чийгийг үнэмлэхүй чийгийн багтаамжид харьцуулсан харьцаа
E. Агаарын үнэмлэхүй чийг ба чийгийн багтаамж хоёрын нийлбэр
8. Энэ газарзүйн ямар бүслүүрийн шинж вэ? (Зунд халуун бүслүүрийн, өвөлд сэрүүн бүслүүрийн агаарын орчил ээлжлэн ноёрхдог, дотоод ялгаа ихтэй, эх газруудын төв хэсгээр их хуурай. Эх газруудын зүүн эргээр муссоны нөлөө их тул чийглэг, холимог ойтой)
А. Сэрүүн бүслүүр В. Халуун бүслүүр С. Дулаан бүслүүр
D. Экватор орчмын бүслүүр E. Туйлын бүслүүр
9. Далай тэнгисийн урсгал үүсэх хамгийн гол хүчин зүйл юу вэ?
А. Тогтмол салхи В. Усны температурын ялгаа
C. Эх газрын хэлбэр D. Усны давсжилт E. Дэлхий нарыг тойрох
10. Газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүд дэлхийн хаагуур орших вэ?
А. Далайн эргээр В. Өндөр уулын бүсэд С. Далайн ёроолоор
D. Тектоникийн хавтангийн хил заагаар E. Эх газар ба далайн заагаар
11. Европ тивд байдаг Дэлхийн далайд гарцгүй улсын нэр юу вэ?
А. Унгар В. Афганистан С. Мали
D. Болив E. Парагвай
12. Зондын арлууд дээр орших хаант засаглалтай улс аль нь вэ?
А. Индонези В. Филиппин С. Бруней
D. Дорнод Тимор E. Малайз
13. Ядуу “Өмнөд” гэсэн хөгжлийн бүлэгт бүх улсууд нь багтдаг эх газар аль нь вэ?
А. Америк В. Европ С. Ази
D. Африк E. Австрали
14. Сахарын цөл, Нил мөрний ай савд орших Африкийн бүс нутаг аль нь вэ?
А. Хойд Африк В. Өмнөд Африк С. Дорнод Африк
D. Төв Африк E. Баруун Африк

15. Монгол Алтайд орших Хотон, Толбо, Даян зэрэг нуурууд ямар гарал үүсэлтэй вэ?
 А. Мөстлөгийн В. Тектоник С. Галт уулын
 D. Элэгдлийн E. Салхины
16. Дэлхийн нүүрсний ихэнх нөөц төвлөрдөг улсууд аль нь вэ?
 А. АНУ, ОХУ, БНХАУ В. БНХАУ, Энэтхэг, Бразил С. ОХУ, Иран, Катар
 D. ӨАБНУ, АНУ, Австрали E. Казахстан, Узбекистан, Иран
17. Цагаан тугалганы нөөц, олборлолтоор тэргүүлэх бүс нутаг, улс аль нь вэ?
 А. Өмнөд Америк, Перу, Бразил, Болив В. Зүүн Өмнөд Ази, БНХАУ, Малайз, Индонези
 С. Зүүн Ази, Япон, БНСУ, БНХАУ D. Баруун Африк, Гвиней, Гана, Зааны Ясан эрэг
 E. Дорнод Африк, Танзани, Сомали, Кени
18. Дамжин өнгөрөх Өрнө Дорнын усан тээврээс улсынхаа төсвийн гуравны нэгийг бүрдүүлдэг улс аль нь вэ?
 А. Египет В. Турк С. БНХАУ
 D. ОХУ E. Казахстан
19. Дараах голуудаас аль нь Хойд мөсөн далайн ай савд багтдаг вэ?
 А. Сэлэнгэ, Чулуут В. Онон, Хэрлэн С. Тэс, Бодонч
 D. Эг, Таац E. Улз, Байдраг
20. Чулуун мандлын бүрэлдэхүүнд ямар 2 элемент давамгайлдаг вэ?
 А. Si, O В. Fe, Na С. Si, Al D. Ca, K E. Cl, Na
21. Дараах зурагт 2 тоогоор далайн ямар урсгалыг тэмдэглэсэн байна вэ?


- А. Фолклендийн хүйтэн урсгал
 В. Баруун зүгийн салхины урсгал
 С. Гвиан дулаан урсгал
 D. Перугийн хүйтэн урсгал
 E. Пассат хоорондын нөхөх урсгал



22. Уст давхарга гадаргад ойрхон газраас гүний ус ундрэн гарахыг юу гэх вэ?
 А. Шанд В. Рашаан С. Артезийн ус D. Булаг E. Ул хөрсний ус
23. Далайн дулаан урсгал гэж юу вэ?
 А. Усны температур нь 20°C-аас дээш
 В. Усны температур нь жилийн дундаж температураас илүү
 С. Усны температур нь орчныхоо уснаас дулаан
 D. Ус нь өвөлдөө хөлддөггүй
 E. Усны температур нь 10°C-аас дээш
24. Галт уулшлыг дэлбэрэх хугацаагаар нь хэрхэн ангилдаг вэ?
 А. Бялхаж буй, унтарсан В. Бялхаж буй, дахин сэргэсэн
 С. Унтарсан, үе үе дэлбэрдэг D. Бялхаж буй, үе үе дэлбэрдэг
 E. Унтарсан, дахин сэргэсэн
25. Тунадас ордог гол үүлний нэр юу вэ?
 А. Борооны давхраат В. Давхраат С. Давхраат бөөн
 D. Өндрийн бөөн E. Бөөн
26. Жил нь хамгийн урт үргэлжилдэг гариг аль нь вэ?
 А. Бархасбадь В. Далай ван С. Сугар
 D. Дэлхий ван E. Тэнгэрийн ван
27. Дараах зүйлсийн аль нь голын үйл ажиллагаатай холбоогүй вэ?
 А. Татам В. Хүрхрээ С. Голын эрэг
 D. Морений хурдас E. Голын хөндий
28. Дараах хариултуудаас 1 : 500 000 масштабтай зургийн хуудасны нэрлэлийг сонгоно уу?
 А. L - 48 - А В. L - 48 С. L - 48 - 123 D. L - 48 - А - а E. L - 48 - XXI

29. Ажилгүйдлийн жирийн түвшингээс давж гарсан ажилгүйдлийн хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ?
 А. Илүүдэл ажилгүйдэл
 В. Мөчлөгийн ажилгүйдэл
 С. Ажилгүйдлийн жирийн түвшин
 D. Энгийн ажилгүйдэл
 E. Ажлын байрны дутагдал
30. Аж үйлдвэрийн тэргүүлэгч “гурван” салбар аль нь вэ?
 А. Машин, электроник, хими
 В. Хими, олборлох, хөнгөн
 С. Эрчим хүч, машин, хими
 D. Электроник, хүнс, хөнгөн
 E. Хүнс, барилгын материал, хими
31. А хотын уур амьсгалын диаграммыг ажиглаж агаарын температур (графикаар) ба тунадасны (диаграммаар) харьцаагаараа уур амьсгалын аль бүсэд хамаарагдахыг тодорхойлно уу.


- А. Тропикийн саванны
 В. Субтропикийн муссоны
 С. Сэрүүн бүсийн тайгын
 D. Сэрүүн бүсийн хээрийн
 E. Газар дундын тэнгисийн



С. Дагуур тэрэлж


32. Дараах нэн ховор ургамлуудаас аль нь хээрийн бүсэд ургадаг вэ?
 А. Хулан хойрго
 В. Монгол тост
 D. Нөмрөгт банздоо
 E. Ямаан сэрдэг
33. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр ойрын өдрүүдэд агаарын даралт буурна гэлээ. Тэнгэр ямар болох вэ?
 А. Тэнгэр муухайрна, тогтворгүй болно, дулаарна
 В. Тэнгэр цэлмэж, тогтуун болно
 С. Салхигүй болно
 D. Цаг агаар тогтвортой болно
 E. Хур тунадасгүй болно
34. Дараах зураг дээр С, D үсгээр тэмдэглэсэн хоёр улс аль нь вэ?

- А. С - Саудын Араб, D - Алжир
 В. С - Пакистан, D - Египет
 С. С - Танзани, D - Пакистан
 D. С - Боливи, D - Сомали
 E. С - Иран, D - Ливи



35. Дараах үйл явцуудаас аль нь экзоген гаралтай вэ?
 А. Тектоникийн хавтангууд бие биенийхээ хажуугаар шилжих
 В. Рифтийн хөндий үүсэх
 С. Галт уул дэлбэрэх
 D. Хөлдөлтөөс болж хөрс хагарах
 E. Магма газрын царцдаст давхарга руу түрж царцах
36. Дараах зурагт стратосферийн давхаргыг ямар үсгээр тэмдэглэсэн байна вэ?


- А. А
 В. Б
 С. В
 D. Г
 E. Д



37. Дараах шинжүүдийн аль нь босоо хөгжлийн борооны бөөн үүлний шинж вэ?
 А. Маш бараан өнгөтэй, зузаан, нягт, аянга цахилгаантай аадар бороо мөн мөндөр орно
 В. Нягт, хавтгай, хэсэгчлэн бөөгнөрсөн, цэнхэр саарал өнгөтэй
 С. Саарал өнгөтэй, бөөгнөрсөн, тэнгэрийг нэлд нь бүрхэнэ, үргэлжилсэн шиврээ бороо орно
 Д. Тунадас ордог гол үүл, бараан саарал өнгөтэй, давхраатсан
 Е. Цагаан саарал өнгөтэй, хөвөн мэт хэсэг хэсгээр тасран бөөгнөрнө, тунадасгүй

38. Монгол улсын газрын зурагт 2 тоогоор тэмдэглэсэн хилийн боомтын нэр юу вэ?


- А. Гашуунсухайт
 В. Бичигт
 С. Баянхошуу
 Д. Хавирга
 Е. Шивээхүрэн



39. Түлш эрчим хүчний станцыг нүүрсээр хангадаг нүүрсний уурхайнууд аль нь вэ?
 А. Адуунчулуун, Талбулаг, Чандган
 В. Шарын гол, Багануур, Шивээ овоо
 С. Хөшөөт, Зээгт, Хар тарвагатай
 Д. Могойн гол, Баянтээг, Нүүрст Хотгор
 Е. Чандган, Шивээ овоо, Нүүрст Хотгор

40. Зурагт үзүүлсэн а, b, c цэгүүдийн өндрийн харьцааг зөв бичсэн хариултыг сонгоно уу.

- А. $a = b < c$
 В. $a < b < c$
 С. $a > b > c$
 Д. $a > b = c$
 Е. $a = b > c$



41. Евразийн уур амьсгал эх газрын дотоодод харилцан адилгүй байна. Уур амьсгал ийнхүү ялгаатай байгаад нөлөөлж буй хүчин зүйл аль нь вэ?

- А. Баруун зүгийн салхи
 В. Арктикийн агаарын масс
 С. Төв азийн их даралтын муж
 Д. Муссон салхи
 Е. Төв азийн бага даралтын муж

42. Сарны харагдах хэлбэр нэг сарын туршид байнга өөрчлөгдөж байдаг нь доорх зүйлсийн алинтай нь холбоотой вэ? Хамгийн зөв хариултыг сонгоно уу.

- А. Сар дэлхийг тойрдог
 В. Дэлхий нарыг тойрдог
 С. Сар, дэлхий, нар гурвын харилцан байрлал өөрчлөгддөг
 Д. Нарны гэрэл саран дээр тусдаг
 Е. Дэлхий тэнхлэгээ эргэдэг учраас

43. Далайн гадарга орчмын усны давсжилт өргөрөг бүсээр өөрчлөгддөг бөгөөд аль бүсүүдэд давсжилт бага байх вэ?

- А. 1, 4, 5
 В. 2, 4, 5
 С. 1, 3, 5
 Д. 3, 4, 5
 Е. 2, 3, 4
- 90° _____ 1
 30° _____ 2
 0° _____ 3
 30° _____ 4
 10° _____ 5

44. Галт уул дэлбэрэх, газар хөдлөх зэрэг тектоник үйл явцад хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг үелэл аль нь вэ?

- А. Астеносфер
 В. Атмосфер
 С. Литосфер
 Д. Тропосфер
 Е. Мезосфер

45. Дараах уулсыг зүүнээс баруун тийш орших дарааллаар нь зөв бичсэн хариултыг сонгоно уу.

- Уулс:
 /а/-Батхаан
 /б/-Цамбагарав
 /в/-Отгонтэнгэр
 /г/-Асралт Хайрхан
 /д/-Таванбогд
- А. б - а - г - д - в
 В. г - а - д - б - в
 С. а - г - б - в - д
 Д. а - б - д - в - г
 Е. г - а - в - б - д

46. Тропосферийн агаар ямар замаар халах вэ?
 А. Нарны ирж байгаа цацрагаас шууд хална
 В. Нарны цацраг агаарт сарних явцад
 С. Газрын гадаргаас дулааныг шингээх замаар
 D. Дэлхийн дотоод дулааны нөлөөгөөр
 E. Нарны хэт ягаан туяанаас

47. Дэлхийн гадаргын зургийг ажиглаад одоогоос ямар хугацааны өмнөх дүр төрх болохыг нь тодорхойлно уу.
 А. 200 сая жил
 В. 135 сая жил
 С. 225 сая жил
 D. 65 сая жил
 E. 20 сая жил



48. Хүний хөгжлийн индексээр улс орны хөгжлийн түвшин, хүн амын амьдралын түвшинг илэрхийлдэг. Схемийн дутууг гүйцээх хариултыг олно уу. (2 оноо)

- А. Бичиг үсэг тайлагдлын дундаж түвшин
 В. Ажилгүйдлийн түвшин
 С. Хүн амын дундаж наслалт
 D. Хүн ам зүйн ачаалал буюу 100 тэжээгч насныханд тэжээлгэгчийн тоо
 E. Хүний хөгжлийн индексээр дэлхийд Норвег улс тэргүүлдэг




49. Хөдөлмөрийн насны хүн ам гэсэн ойлголтонд дараах хариултуудаас аль нь тохирох вэ?
 А. 16-60 хүртэлх насны эрэгтэйчүүд, 16-55 хүртэлх насны эмэгтэйчүүд
 В. 16-60 хүртэлх насны эрэгтэйчүүд, 16-55 хүртэлх насны эмэгтэйчүүдийн нийт тооноос хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоог хасч гаргасан үзүүлэлт
 С. 16-60 хүртэлх насны эрэгтэйчүүд, 16-55 хүртэлх насны эмэгтэйчүүдийн нийт тоон дээр 16 доош насны хөдөлмөр эрхлэгсдийн тоог нэмж гаргасан үзүүлэлт
 D. Сайн дураараа биш ажил эрхлээгүй байгаа хөдөлмөрийн чадвартай, ажил идэвхитэй эрж буй боловч ажил олж чадахгүй байгаа хүмүүс
 E. Ажиллагсад болон хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тооны нийлбэр
50. 1:15 000 000 масштабтай зураг дээр 2 см зурагдсан зай 1: 30 000 000 масштабтай зураг дээр хэдэн см зурагдахыг бодож олно уу.

- А. 4 см
 В. 2 см
 С. 2,5 см
 D. 1 см
 E. 3 см


51. Атлантын далайн гадаргын усны дундаж давсжилт нь бусад далайтай харьцуулахад илүү их байдаг. Гэвч мэлхийн зам дээр орших А цэг дээр давсжилт нь Б цэгийнхээс их байдгийн гол шалтгаан юу вэ?

- А. Тунадас их
 В. Ууршилт бага
 С. Далайн дулаан урсгалын нөлөө
 D. Агаарын даралт их, тунадас бага
 E. Гадарга ба ургамлын бүрхэвч



52. Улаанбаатар хот $X\Theta 47^{\circ} 51'$, $3Y 106^{\circ} 51'$ -д оршдог. Тэгвэл мэлхийн зам дээр нар эгц тусч байх үед Улаанбаатар хотод үдийн нарны өндөр хэд байхыг бодож олно уу?
- А. $65^{\circ} 36'$
 В. $106^{\circ} 51'$
 С. $15^{\circ} 36'$
 D. $16^{\circ} 15'$
 E. $35^{\circ} 49'$

53. Дараах зургийг ажиглаад, харлуулсан хуудасны нэрлэл аль нь болохыг тодорхойлно уу.



54. Агаарын температур өөрчлөгдөхөд түүний үнэмлэхүй чийглэгийн багтаамж яаж өөрчлөгдөх вэ?

- A. Температур өсөхөд багасна
- B. Температур буурахад өснө
- C. Температур өсөхөд өснө
- D. Температур буурахад багасна
- E. Хэвээр байна

55. Хүснэгтэнд өгөгдсөн мэдээллүүдийг зөв тохируулан сонгосон хариулт аль вэ?

Тэнгисийн нэр	Дугаар	Далайн нэр	Тэмдэглэгээ
Улаан	1	Номхон	а
Балтын	2	Хойд мөсөн	б
Шар	3	Атлантын	в
Карын	4	Энэтхэгийн	с

- A. 1в, 2а, 3с, 4б
- B. 1с, 2б, 3б, 4а
- C. 1б, 2а, 3с, 4б
- D. 1с, 2в, 3а, 4б
- E. 1с, 2б, 3б, 4с

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга


- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Хэрэв бодлогын хариу 98 гарсан гэж үзвэл а-9, в-8 гэж бөглөнө, 1967 гэж гарсан бол а-1, в-9, с-6, d-7 гэж бөглөнө.
- Цагийн бодлогын хариуг доорх хэлбэрээр бөглөнө. Жишээлбэл: өглөөний 6 цаг бол 06 буюу а-0, б-6, оройн 6 цаг бол 18 буюу а-1, б-8 гэж бөглөнө.

2.1. Зуунмод хотод агаарын температур 0°C (Үнэмлэхүй чийгийн багтаамж 6 гр /м³), харьцангуй чийг 50% байна гэвэл агаарын үнэмлэхүй чийгийг ол.


2.2. Өвөл Монголд ирсэн Канадын жуулчинд -25° C хүйтнийг Франгейтийн хувиараар хэд байхыг зөв хэлэх хариултыг сонгоно уу.

- A. -13
- B. -30
- C. -20
- D. -16
- E. 10

2.3. Анхны голдоч дээр 09 : 00 цаг болж байхад аль уртраг дээр 04 : 00 цаг болж байх вэ?



2.4. Агаарын бөмбөлөг 500 м өндөрт нисэж байлаа. Энэ үед газрын гадарга дээр агаарын температур 16°C байсан бол агаарын бөмбөлөг нисэж яваа өндөрт агаарын температур хэдэн градус байх вэ?




ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ


- Дэлхийн гурван гол шашны нэг нь лал юм. Энэ шашин өргөн дэлгэрсэн улс орон аль нь вэ?
 А. Герман, АНУ В. Австрали, ОХУ С. Турк, Пакистан
 D. Энэтхэг, Лаос E. Тайланд, Хятад
- Экватор дээр жилд хэдэн удаа нар эгц тусдаг вэ?
 А. 2 В. 1 С. Эгц тусдаггүй D. 3 E. 4
- Нарны хэт ягаан туяаг өөртөө шингээдэг хий аль нь вэ?
 А. Усны уур В. CO₂ С. Озон
 D. Гелий E. Инертийн хий
- Дараах цөлүүдээс аль нь Номхон далайн эрэг дагууд орших вэ?
 А. Руб-Эль-Хали В. Каракум С. Атакам
 D. Такла-Макан E. Намиб
- Туйл орчимд тропосферийн өндөр хэд байдаг вэ?
